

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2008 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 180

Улаанбаатар хот

“Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ыг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Хоршооны тухай хуулийн 8.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1. “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 17 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоож, хяналт тавих журам”-ыг хүчингүй болгосугай.
3. Журамд заасан зохистой харьцааны хүрээнд үйл ажиллагаагаа явуулахыг Хадгаламж, зээлийн хоршооны Тэргүүлэгчид, Хоршооны дарга, Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

/Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор орсон өөрчлөлтийг тусгав/

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ
ТООЦОЖ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13.7 дахь заалтад заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо (цаашид Хороо гэх)-ноос хадгаламж, зээлийн хоршоо (цаашид ХЗХ гэх)-нд дагаж мөрдөх санхүүгийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, зээлийн эрсдэлийн санг байгуулах хувь хэмжээг тодорхойлох болон бусад хэм хэмжээг тогтоох түүний хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага хүлээлгэх харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

/Энэ хэсгийг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

1.2. ХЗХ нь өөрийн үйл ажиллагаандаа учирч болзошгүй эрсдэлийг дараах зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн дагуу тооцож, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана. Үүнд:

/Энэ хэсгийг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

1/ Активын чанарын болон хамгаалалтын үзүүлэлт;

/Энэ заалтыг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

2/ Үр ашигтай санхүүгийн бүтцийн үзүүлэлт;

3/ Өгөөж, зардлын хувь хэмжээний үзүүлэлт;

4/ Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт;

/Энэ заалтыг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

1.3. ХЗХ нь энэ журмын 1.2-т заасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг үнэн зөв тооцож, түүний өөрчлөлтөд нөлөөлсөн хүчин зүйл, шалтгааныг тогтоон үнэлэлт, дүгнэлт өгөх замаар хоршооны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тооцох, түүнээс сэргийлэх арга хэмжээг авна.

/Энэ хэсгийг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

1.4. ХЗХ нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой бүх төрлийн эрсдэлийг үнэлэх, хяналт тавьж, удирдах зорилгоор нэмэлт журмыг дотооддоо боловсруулан мөрдүүлж болно. Тэдгээр нь Хадгаламж, зээлийн хоршооны тухай болон холбогдох бусад хууль, журамтай нийцсэн байна.

/Энэ хэсгийг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

1.5. Энэ журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

1/ Актив гэдэг нь ХЗХ-ны үйл ажиллагааны үр дүнд үүсч бий болсон, түүний мэдэлд байгаа, ирээдүйд эдийн засгийн үр ашиг өгөх санхүүгийн нөөц болон чадавхийг;

/Энэ заалтыг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

2/ Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө (цаашид ӨБҮХХ гэх) гэдэг нь зөвхөн зээл төлөлтийн тооцоогоор (зээлдэгчээс зээлийн барьцаанд тавьсан үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах зорилгоор хураан авсан хөрөнгө) бусдаас өмчлөн авахад хүрсэн, ХЗХ-ны үйл ажиллагаанд хамааралгүй үл хөдлөх хөрөнгийг;

/Энэ заалтыг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

3/ Үндсэн хөрөнгө гэдэг нь нэг жилээс дээш хугацаанд ашиглагдах, ашиглалтын боломжит хугацаа нь хязгаарлагдмал, худалдах зориулалтгүй, ХЗХ-ны хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн, элэгдлийн үндсэн дээр өртөг, зардалд анхны үнээ аажмаар шингээж байдаг биет хөрөнгийг;

/Энэ заалтыг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

4/ Зээл гэдэг нь тодорхой зориулалт, хугацаа, эргэж төлөгдөх нөхцөл, хүү, барьцаа, баталгаа эсвэл батлан даалттайгаар хоршооноос өөрийн гишүүнд шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг;

5/ Зээлийн эрсдэлийн сан гэдэг нь ирээдүйд учирч болох эрсдэлээс хамгаалах зорилгоор урьдчилан тооцож ХЗХ-ны зардлаар байгуулсан санг;

/Энэ заалтыг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

6/ Хувь хөрөнгө гэдэг нь гишүүд эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор ХЗХ-нд элсэхэд оруулсан мөнгөн хөрөнгийг;

/Энэ заалтыг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

7/ Хоршоологчдын өмч гэдэг нь ХЗХ-ны өөрийн хөрөнгөөс хувь хөрөнгийн дүнг хассаны дараах хөрөнгийг;

/Энэ заалтыг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

8/ Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар гэдэг нь бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө болон бусад төлбөрийн нэхэмжлэлийг анхны шаардлагаар гүйцэтгэх чадамжийг;

/Энэ заалтыг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

9/ Түргэн борлогдох актив гэдэг нь касс дахь бэлэн мөнгө, банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламжийн үлдэгдлийн нийлбэрийг;

/Энэ заалтыг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

10/ Богино хугацаат өр төлбөр гэдэг нь гишүүдийн хугацаагүй хадгалуулсан мөнгөн хөрөнгө, нэг жил хүртэлх хугацаатай банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл, төсөл, хөтөлбөрийн зээл болон бусад өр төлбөрийг;

/Энэ заалтыг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

11/ Өөрийн хөрөнгө гэдэг нь активаас өр төлбөрийг хассан зөрүү буюу хувь хөрөнгө болон хоршоологчдын өмчийн нийлбэрийг.

/Энэ заалтыг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор нэмсэн/

ХОЁР. АКТИВЫН ЧАНАРЫН БОЛОН ХАМГААЛАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ

/Энэ зүйлийн гарчгийн хэсгийг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

2.1. Актив нь касс дахь бэлэн мөнгө, банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламжийн үлдэгдэл, гишүүдэд олгосон зээл, авлага, бусад актив, үндсэн болон өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгөөс бүрдэнэ.

/Энэ хэсгийг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

2.2. ХЗХ-ны гишүүдэд олгосон зээлийн багцад Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан 2010 оны 8 дугаар сарын сарын 11-ний өдрийн 475/182 дугаар тушаалаар батлагдсан

“Активыг ангилах, активын эрсдлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу ангилал хийж, зээлийн эрсдэлийн санг байгуулна.

/Энэ хэсгийг Хорооны 2010 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 245 дугаар тогтоолоор өөрчлөн найруулж, 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

2.3. Зээл, ӨБҮХХ болон бусад активтай холбоотой гэрээ, хэлцлийн дагуу үүрэг хүлээсэн этгээд нь үндсэн зээл, түүний хүүгийн төлбөрийг бүхэлд нь болон хэсэгчлэн буцаан төлөх чадваргүй болж болзошгүй нь үндэслэл бүхий баримт (зээлийн гэрээний хугацаа дууссан, барьцаа хөрөнгийн чанар муудсан, зах зээлийн үнэ буурсан, байгалийн болон гэнэтийн эрсдэл учирсан гэх мэт)-аар тогтоогдвол хоршоо нь эрсдэлийн санг зардлаар байгуулна.

2.4. Хэвийн ангилалд байгаа зээл, авлагыг санхүүгийн тайлан тэнцэлд анх тусгах үед эрсдэлийн санг байгуулахгүй.

2.5. Хэвийн зээлд эрсдэлийн сан байгуулсан тохиолдолд санхүүгийн тайланд холбогдох үндэслэл, шийдвэр, баримт материалыг хавсаргаж Хороонд ирүүлнэ.

2.6. Зээл, ӨБҮХХ болон бусад активыг ангилахад хугацааны үзүүлэлт нь үндсэн хүчин зүйл, чанарын үзүүлэлт нь харгалзах хүчин зүйл байх болно. Хугацааны ба чанарын үзүүлэлтийг энэ бүлгийн 3.2-д заасан журмын хавсралтад заасан хүчин зүйлсээр тооцон ангилна.

2.7. Зээл, бусад активын эрсдэлийн санг хугацааны болон чанарын үзүүлэлт өөрчлөгдөх тухай бүр дараах ангиллаар ангилах бөгөөд актив хөрөнгийн хамгаалалтыг доорх хувь хэмжээгээр байгуулна. Үүнд:

1/ Хэвийн зээл	
2/ Хугацаа хэтэрсэн	5 хувь
3/ Чанаргүй, үүнээс:	
а/ хэвийн бус	25 хувь
б/ эргэлзээтэй	50 хувь
в/ муу	100 хувь

/Журмын 2.2 дахь хэсгийг Хорооны 2010 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 245 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан тул энэ хэсгийг Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан 2010 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 475/182 дугаар тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу өөрчлөн найруулсан/

2.8. Чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл нь нийт зээлийн багцын 5 хувиас хэтрэхгүй байвал зохино.

/Энэ хэсгийг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

2.9. ХЗХ-ны нэг гишүүн болон нэгдмэл сонирхолтой этгээдэд олгосон нийт зээлийн дүн нь өөрийн хөрөнгийн 30 хувиас ихгүй байвал зохино.

/Энэ хэсгийг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

ГУРАВ. ҮР АШИГТАЙ САНХҮҮГИЙН БҮТЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ

3.1. АКТИВ

1/ Цэвэр зээлийн өрийн үлдэгдэл нь нийт активын 60-80 хувь байвал зохино.

/Энэ заалтыг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

2/ ӨБҮХХ нь нийт активын 5 хувиас хэтрэхгүй байвал зохино. (ӨБҮХХ-ийн нийт активд эзлэх хувийн жин нь нэмэгдэж байгаа нь хоршооны зээлийн эргэн төлөлт муу байгааг харуулж, хоршооны эх үүсвэрийн хомсдолыг бий болгодог)

/Энэ заалтыг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

3/ ХЗХ-ны цэвэршүүлсэн үндсэн хөрөнгө нь нийт активын 10 хувиас хэтрэхгүй байвал зохино.

/Энэ заалтыг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

3.2. ЭХ ҮҮСВЭР

1/ Гишүүдээс хадгалуулсан мөнгөн хадгаламжийн нийт дүн нь нийт активын 80 хүртэлх хувь байвал зохино.

/Энэ заалтыг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

2/ ХЗХ-ны банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл, төсөл, хөтөлбөрийн зээл нь нийт активын 20 хувиас хэтрэхгүй байвал зохино.

/Энэ заалтыг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

3/ Гишүүдийн хувь хөрөнгийн хэмжээ нь нийт активын 5 хувиас дээш, нэг гишүүний оруулж болох хувь хөрөнгийн хэмжээ нь нийт хувь хөрөнгийн 10 хувиас хэтрэхгүй байвал зохино.

/Энэ заалтыг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

4/ ХЗХ-ны жилийн тайлант хугацааны эцэс дэх цэвэр ашгаас байгуулах нөөцийн сан нь хоршоологчдын өмчийн 15 хувиас доошгүй байвал зохино.

/Энэ заалтыг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

ДӨРӨВ. ӨГӨӨЖ, ЗАРДЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

4.1. ХЗХ болон тухайн ХЗХ-г хариуцсан ажилтнаас дор дурдсан өгөөж, харьцаануудыг тооцож, ХЗХ-дын нэгтгэлийн дундажтай харьцуулан санхүү, төлбөрийн чадвар болон бусад үзүүлэлтэд үнэлгээ, дүгнэлт өгнө. Үүнд:

/Энэ хэсгийг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

~~4.2 Зээлийн багцын өгөөжийг тооцходоо зээлийн хүүгийн орлогыг зээлийн багцын дунджид харьцуулна.~~

/Энэ хэсгийг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/

4.3. ХЗХ-ны үйл ажиллагааны зардал нь хөрөнгийн удирдлагатай холбоотой бөгөөд нийт активын 15 хувиас хэтрэхгүй байвал зохино.

/Энэ хэсгийг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

4.4. Активын өгөөж нь нэг төгрөгийн актив хөрөнгөөс ямар хэмжээний орлого олж байгааг харуулах бөгөөд татварын өмнөх цэвэр ашгийг нийт активын дундажтай харьцуулан тооцно.

/Энэ хэсгийг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

4.5. ХЗХ-ны үйл ажиллагааны үр дүн, ашиг алдагдал, зардлыг хэрхэн удирдаж, хэмнэлт гаргах, санхүүгийн тогтвортой байдал, бодит өсөлтийг хэрхэн удирдахыг тооцоолно. Тухайлбал;

/Энэ хэсгийг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

1/ Хүүгийн орлого, нийт дундаж активын харьцаа: Зээлийн хүүгийн орлогыг нийт активын дундаж үлдэгдэлд;

/Энэ заалтыг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

2/ Хүүгийн зардал, нийт дундаж активын харьцаа: Бүх төрлийн хүүний зардлыг активын дундаж үлдэгдэлд;

/Энэ заалтыг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

3/ Хүүгийн цэвэр орлого, нийт дундаж активын харьцаа: Бүх төрлийн хүүгийн орлогоос хүүгийн зардлыг хассан дүнг активын дундаж үлдэгдэлд;

/Энэ заалтыг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

4/ Хүүгийн бус орлого, нийт дундаж активын харьцаа: Ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого, бусад төрлийн орлогуудын нийлбэр дүнг активын дундаж үлдэгдэлд;

/Энэ заалтыг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

5/ Хүүгийн бус зардал, нийт дундаж активын харьцаа: Ханш болон үнэлгээний тэгшитгэлийн зардал, боловсон хүчний холбогдолтой зардал, болзошгүй эрсдэлийн зардал зэрэг хүүгийн бус зардлуудын нийлбэр дүнг активын дундаж үлдэгдэлд;

/Энэ заалтыг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

6/ Эрсдэлийн сангийн зардал, нийт дундаж активын харьцаа: Бүх төрлийн болзошгүй эрсдэлийн зардлуудын нийт дүнг активын дундаж үлдэгдэлд;

/Энэ заалтыг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

7/ Хүүгийн орлого, хүүгийн орлого оруулдаг нийт дундаж активын харьцаа: Бүх төрлийн хүүний орлогыг хүүгийн орлого оруулдаг нийт активын дундаж үлдэгдэлд;

/Энэ заалтыг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

8/ Зээлийн эрсдэлийн сан, нийт зээлийн өрийн үлдэгдлийн харьцаа: Зээлийн эрсдэлийн санг нийт зээлийн өрийн үлдэгдэлд тус тус харьцуулан дүгнэлт хийнэ.

/Энэ заалтыг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

ТАВ. ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

5.1. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлийн түвшинг тооцохдоо түргэн борлогдох активаас богино хугацаат өр төлбөрийг хасч, гишүүдээс татан төвлөрүүлсэн хадгаламжид харьцуулах замаар тооцно. Энэ харьцаа нь 5 хувиас дээш байвал зохино.

ЗУРГАА. БУСАД

6.1. Энэхүү журамд заагдсан зохистой харьцааг ханган ажиллаж байгаа эсэхэд ХЗХ-ны бүх гишүүдийн хурал, тэргүүлэгчид, хяналтын зөвлөл, зээлийн хороо болон ХЗХ-ны дарга, гүйцэтгэх удирдлага нь хууль тогтоомжоор олгогдсон эрхийнхээ хүрээнд хяналт тавьж, хангуулахтай холбогдуулан зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллана.

/Энэ хэсгийг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

6.2. ХЗХ нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг энэхүү журмын хавсралтуудын дагуу улирал бүр тооцож, санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлнэ. Үүнд:

/Энэ хэсгийг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

1/ Хураангуй тайлан, тэнцэл /Хавсралт 1/;

/Энэ заалтыг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

2/ Орлого, зарлагын тайлан /Хавсралт 2/;

3/ 20 том зээлдэгч, нэгдмэл сонирхолтой этгээдэд олгосон зээл болон бусад актив хөрөнгийн тайлан /Хавсралт 3/;

/Энэ заалтыг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

4/ Их хэмжээний хувь хөрөнгө нийлүүлсэн гишүүдийн тайлан /Хавсралт 4/;

5/ Актив, пассивын эргэн төлөгдөх хугацааны тайлан /Хавсралт 5/;

6/ Активын чанарын болон хамгаалалтын үзүүлэлтийн тайлан /Хавсралт 6/;

7/ Үр ашигтай санхүүгийн бүтцийн үзүүлэлтийн тайлан /Хавсралт 7/;

/Энэ заалтыг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

8/ Өгөөж, зардлын хувь хэмжээний үзүүлэлтийн тайлан /Хавсралт 8/;

/Энэ заалтыг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

9/ Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтийн тайлан /Хавсралт 9/

/Энэ заалтыг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчилсөн/

10/ Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн хураангуй

6.3. Тухайн хоршоо нь зөвхөн зээлийн үйл ажиллагаа эрхлэхээр Хорооноос тусгай зөвшөөрөл авсан бол Хорооны даргын шийдвэрээр энэхүү журамд заасан зарим үзүүлэлтийг тооцохгүй байхаар тогтоож болно.

6.4. Энэхүү нэмэлт өөрчлөлт оруулсан журам мөрдөгдөж эхэлснээс хойш хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан ХЗХ нь Хорооноос тусгай зөвшөөрөл олгогдсоноос хойшхи 2 улиралд багтаан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан байх үүргийг хүлээнэ.

/Энэ хэсгийг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

6.5. Хорооны 2012 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам”-д заасны дагуу зохистой харьцааны шалгуур үзүүлэлт хангагдаагүй үндэслэлээр тухайн ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох тайлант хугацааны эхлэлийг энэ журмын 6.4-д заасан хугацаанаас хойш тооцно.

/Энэ хэсгийг Хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор нэмсэн/